

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/102/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Э.Энхбаатар  
Утас: 51-260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn  
Ахлах аудитор: О.Баярмаа  
Утас: 51-261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn  
Аудитор: Г.Сампилмаа  
Утас: 51-261740 Цахим хаяг: sampilmaag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	8
3.1 Зохицуулах хороо, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Хорооны гадаад, дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	8
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	9
3.4.2 Авлага .....	9
3.4.3 Урьдчилгаа .....	10
3.4.4 Бараа материал .....	10
3.4.5 Үндсэн хөрөнгө .....	10
3.4.6 Өр төлбөр .....	11
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо .....	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	12
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин .....	12
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	12
3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар .....	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Харьяа зохицуулах зөвлөлүүд .....	15
5.2 Эрчим хүчний зохицуулах хороо .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 06/783  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА  
Э.ТҮВШИНЧУЛУУН ТАНАА

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Эрчим хүчний зохицуулах хороо болон аймаг, нийслэлийн 22 зохицуулах зөвлөлийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн “зохицуулалтын үйлчилгээний хөлсийг баталсан аргачлалын дагуу тооцоогүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй үйлчилгээний хөлс төлөх тухай гэрээ байгуулж ажиллаагүй, авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу” зэрэг 218.9 сая төгрөгийн зөрчил бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.4, 20.2.6-д заасантай тус тус нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс үйлчилгээний хөлс 8,280.0 сая төгрөг, 20 аж ахуйн нэгжид 21 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 42 байгууллагын 75 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйлчилгээний

хөлсний орлогоор 605.1 сая төгрөг, бусад орлогоор 55.7 сая төгрөгийг бүрдүүлж, нийт 8,940.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын төлөвлөгөө 102.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын хэрэгжилтийн хүрээнд 2025 оноос аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн санхүүгийн тайланг нэгтгэн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэж эхэлсэн нь олон нэгжийн мэдээллийг нэгтгэх үйл явцад хяналт, уялдаа сулрах, тайлангийн мэдээлэлд зөрүү, алдаа гарах, бүрэн бус болон давхардсан дүн тусгагдах эрсдэлийг бий болгохоор байна.

### **Бусад асуудал**

Эрчим хүчний зохицуулах хороо нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн цаглаварт хугацаандаа ирүүлж Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг хэрэгжүүлж, аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	779,989.1	1,190,439.7
1.1.2	Дансны авлага	186,016.8	257,733.5
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	60,688.2	20,833.0
1.1.4	Бусад авлага	1,348.9	4,239.9
1.1.6	Бараа материал	15,934.2	14,566.4
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,050.0	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,050,027.1	1,487,812.6
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,083,068.7	4,247,375.7
1.2.2	Биет бус хөрөнгө	90,982.9	75,864.3
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,174,051.6	4,323,240.0
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,224,078.7	5,811,052.5
2.1.1.1	Дансны өглөг	-	4,616.1
2.1.1.2	Цалингийн өглөг	-	9,435.3
2.1.1.3	Татварын өр	-	8,221.5
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	2,765.4
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,052.4	422.3
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,052.4	25,460.6
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	247,590.8	200,821.3
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	247,590.8	200,821.3
2.2	Өр төлбөрийн нийт дүн	249,643.3	226,281.9
2.3.1	Өмч: - төрийн	104,537.5	195,749.5
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	75,906.6	329,068.1
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	35,585.6	71,079.7
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,758,405.8	4,988,873.3
2.3.9.01	Тайлангийн үеийн ашиг	604,026.5	95,816.4
2.3.9.02	Өмнөх үеийн ашиг	4,145,379.3	4,893,056.9
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,974,435.5	5,584,770.7
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,224,078.7	5,811,052.5

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,383,925.0	9,625,102.8
2	Борлуулалтын өртөг	6,267,343.6	8,225,804.4
3	Нийт ашиг ( алдагдал)	1,116,581.4	1,399,298.4
5	Хүүний орлого	4,005.1	6,967.9
8	Бусад орлого	47,940.3	53,937.2
10	Ерөнхий ба удирдлагын зардал	474,099.8	1,303,046.9
11	Санхүүгийн зардал	-	19.0
12	Бусад зардал	-	12,983.4
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(235.3)	(320.4)
17	Бусад ашиг ( алдагдал)	-	(3,269.0)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)	694,191.6	140,564.8

**Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан**

19	Орлогын татварын зардал	90,165.1	44,748.4
20	Татварын дараах ашиг (алдагдал)	604,026.5	95,816.4
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	604,026.5	95,816.4
24	Орлогын нийт дүн	604,026.5	95,816.4

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.0	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,548,129.4	10,887,978.2
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,338,066.6	10,510,367.4
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	196,333.0	190,912.5
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,753.4	6,258.8
	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	151,093.2
	Бусад мөнгөн орлого	11,976.5	29,346.3
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,621,964.9	10,309,675.6
	Ажиллагчдад төлсөн	4,453,556.6	6,133,311.6
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,180,000.0	1,533,846.3
	Бараа материал худалдан авахад төлсөн	152,297.4	143,354.0
	Ашиглалтын зардалд төлсөн	83,596.9	75,405.5
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	43,629.3	84,803.0
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	9.3
	Татварын байгууллагад төлсөн	1,544,745.0	1,721,154.8
	Даатгалын төлбөрт төлсөн	12,154.2	11,970.1
	Бусад мөнгөн зарлага	151,985.5	605,821.1
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	926,164.5	578,302.6
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,005.1	6,967.9
	Хүлээн авсан хүүгийн орлого	4,005.1	6,967.9
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	204,228.4	174,819.9
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	204,228.4	174,819.9
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(200,223.3)	(167,852.0)
5.0	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	725,941.2	410,450.6
6.0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,047.9	779,989.1
7.0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	725,941.2	1,190,439.7

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,370,409.0		4,370,409.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,370,409.0		4,370,409.0
Тайлант үеийн үр дүн	604,026.5		604,026.5
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,974,435.5		4,974,435.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	261,357.3		261,357.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,235,792.8		5,235,792.8
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0		0.0

**Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан**

Өмчид гарсан өөрчлөлт	253,161.5	253,161.5
Тайлант үеийн үр дүн	95,816.4	95,816.4
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,584,770.7	5,584,770.7

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйц	Хувь
<i>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</i>									
1	Зохицуулалтын үйлчилгээний хөлсний орлого	мян.төг	7,383,925.0	8,709,250.6	8,885,119.1	1,501,194.1	120.3	175,868.5	102.0
	Бусад орлого	мян.төг	51,945.3	43,100.0	55,717.4	3,772.1	107.3	12,617.4	129.3
2	Нийт орлого	мян.төг	7,435,870.3	8,752,350.6	8,940,836.5	1,504,966.2	120.2	188,485.9	102.2
3	Нийт зардал	мян.төг	6,741,678.6	9,194,900.0	8,839,250.3	2,097,571.7	131.1	(355,649.7)	96.1
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	474,099.8	644,700.0	641,709.9	167,610.2	135.4	(2,990.1)	99.5
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	694,191.6	(442,549.4)	101,586.2	(592,605.5)	14.6	544,135.6	(23.0)
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	604,026.5	(442,549.4)	57,318.1	(546,708.4)	9.5	499,867.5	(13.0)
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	2,750,605.4	3,234,088.8	3,199,668.8	449,063.3	116.3	(34,420.0)	98.9
	а/ Орлогын татварт	мян.төг	106,870.0	-	31,565.0	(75,305.0)	29.5	31,565.0	
	б/ НӨАТ	мян.төг	749,369.3	825,235.1	844,668.2	95,299.0	112.7	19,433.2	102.4
	в/ НДШ	мян.төг	1,180,000.0	1,584,936.0	1,500,981.2	320,981.2	127.2	(83,954.8)	94.7
	г/ Хүн амын орлогын татвар	мян.төг	475,404.4	633,974.4	591,331.8	115,927.4	124.4	(42,642.6)	93.3
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	37,884.4	37,884.4	37,884.4	-	100.0	-	100.0
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	387.3	1,368.9	1,368.9	981.6	353.4	-	100.0
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	мян.төг	200,690.0	150,690.0	191,869.1	(8,820.9)	95.6	41,179.1	127.3
8	Нийт ажиллагсдын тоо	мян.төг	91.0	98.0	91.0	-	100.0	(7.0)	92.9
9	Нийт цалингийн сан	мян.төг	4,944,786.6	6,603,900.0	6,470,800.0	1,526,013.4	130.9	(133,100.0)	98.0
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	4,528,192.9	5,615,561.2	5,925,641.0	1,397,448.2	130.9	310,079.8	105.5
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	0.9	1.1	1.0	0.1	109.0	(0.1)	94.1
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	204,363.0	89,900.0	83,500.0	(120,863.0)	40.9	(6,400.0)	92.9
13	Нийт авлага	мян.төг	248,053.8	236,300.0	219,880.0	(28,173.8)	88.6	(16,420.0)	93.1
	Үүнээс: Найдваргүй	мян.төг	29,640.0	29,640.0	29,640.0	-	100.0	-	100.0
14	Нийт өглөг	мян.төг	249,643.3	234,000.0	201,240.0	(48,403.3)	80.6	(32,760.0)	86.0
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	2,052.4	33,180.0	420.0	(1,632.4)	20.5	(32,760.0)	1.3
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	247,590.8	200,820.0	200,820.0	(46,770.8)	81.1	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Зохицуулах хороо, түүний үйл ажиллагаа

Эрчим хүчний зохицуулах хороо нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн тарифыг хянаж батлах, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэнэ” гэж тодорхойлсон байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэмд байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, илгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, үнэ тарифыг тогтоох, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх” гэж тодорхойлжээ.

#### 3.2 Хорооны гадаад, дотоод орчин

Эрчим хүчний зохицуулах хороо нь Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрддөг байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн хууль.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Тайлант онд тус хорооны санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байна

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 592.2 сая төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
А	1	2	3=2-1

**Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан**

Мөнгөн хөрөнгө	779,989.1	1,190,439.7	410,450.6
Авлага	248,053.9	282,806.5	34,752.6
Урьдчилгаа	6,050.0	0.0	(6,050.0)
Бараа материал	15,934.2	14,566.5	(1,367.7)
Үндсэн хөрөнгө	4,174,051.6	4,328,436.7	154,385.1
Нийт хөрөнгийн дүн	5,224,078.7	5,816,249.2	592,170.5
Богино хугацаат өр төлбөр	2,052.4	25,460.6	23,408.2
Урт хугацаат өр төлбөр	247,590.8	200,821.3	(46,769.5)
Засгийн газрын хувь оролцоо	4,974,435.5	5,589,967.4	615,531.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,224,078.7	5,816,249.2	592,170.5

*Эх сурвалж: ЭХЗХ-ны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,190.4 сая төгрөг болж, өмнөх оноос 410.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг	779,989.1	1,190,439.7	410,450.6
Кассанд байгаа бэлэн мөнгө	1,573.0	8,808.5	7,235.5
Арилжааны банк дахь харилцах	778,416.1	1,181,631.2	403,215.1
Дүн	779,989.1	1,190,439.7	410,450.6

*Эх сурвалж: ЭХЗХ-ны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 8.3 хувь буюу 99.5 сая төгрөг нь Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Архангай аймгийн Зохицуулах зөвлөл: Тайлант онд "Галт зүрх" ХХК-аас нэхэмжилсэн 3.0 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлсийг Зохицуулах зөвлөлийн 515602866 дансанд төвлөрүүлээгүй байна. Мөн тайлант оны 2,3,4,5,9,12 саруудад 7 удаа хуралдсан бөгөөд орон тооны бус гишүүдэд сар бүр урамшуулал олгож, нийт 7.8 сая төгрөгийг зарцуулсан;
- Баянхонгор аймгийн Зохицуулах зөвлөл: Тайлант хугацаанд байгууллагын даргын гар утасны 0.3 сая төгрөгийн төлбөрийг төлсөн байна. Тус байгууллага нь төсвийг зарцуулахдаа Эрчим хүчний зохицуулах хорооны хянасан зардлын төсвөөс хэтрүүлэн баталж, зарцуулсан байна. Тухайлбал, байгууллагын эзэмшилд тээврийн хэрэгсэл бүртгэлгүй байхад 0.3 сая төгрөгийн масло, маслын шүүр, 0.5 сая төгрөгийн 2ш дугуй, нийт 0.8 сая төгрөгийг зарцуулсан;
- Төв аймгийн Зохицуулах зөвлөл: Тайлант онд мөнгөн зарлагын 39.2 сая төгрөгийн гүйлгээний баримтад гарын үсэг, тамга тэмдэггүй, орлого, зарлагын баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 165 дугаар тогтоолоор Төв аймгийн зохицуулах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг 38.7 сая төгрөгөөр баталснаас, гүйцэтгэлээр 41.9 сая төгрөг зарцуулж, 3.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
- Говьсүмбэр аймгийн Зохицуулах зөвлөл: Орлогын төлөвлөгөөг 1.8 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;
- Дорноговь аймаг Зохицуулах зөвлөл: Зөвлөлийн орон тооны гишүүн 7.9 сая төгрөгийн урамшуулал олгохоор баталсан боловч 12.8 сая төгрөгийн урамшууллыг олгож, нийт 4.9 сая төгрөгийн урамшууллыг илүү олгосон.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 282.8 сая төгрөг болж, өмнөх оноос 34.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,348.9	4,239.9	2,891.0
Дансны авлага	186,016.8	257,733.5	71,716.7
Татварын авлага	60,688.2	20,833.0	(39,855.2)
Дүн	248,053.9	282,806.4	34,752.5

*Эх сурвалж: ЭХЗХ-ны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

**Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан**

Авлага нэмэгдсэн нь 21 аймаг болон нийслэлийн зохицуулах зөвлөлийн нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргасантай холбоотой Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн авлага 62.9 сая төгрөгийн авлагыг бүртгэснээр өссөн байна. Тайлант хугацаанд татварын авлага 39.9 сая төгрөгөөр буурсан.

Аудитын илрүүлэлт:

- Дорнод аймгийн Зохицуулах зөвлөл: 2023 онд үүссэн 4.0 сая төгрөгийн хувь хүнээс авах авлагыг барагдуулаагүй байна.

**3.4.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 6.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	6,050.0	-	(6,050.0)
<b>Дүн</b>	<b>6,050.0</b>	<b>-</b>	<b>(6,050.0)</b>

*Эх сурвалж: ЭХЗХ-ны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Эрчим хүчний зохицуулах хорооны урьдчилгаа данс 6.1 сая төгрөгөөр буурсан нь дахин үнэлгээ хийлгэсэн ажлын тайланг хүлээн авч гэрээг дуусгавар болгосноос шалтгаалсан байна.

**3.4.4 Бараа материал**

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 14.6 сая төгрөг болж, өмнөх оноос 1.4 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	15,934.2	14,566.4	(1,367.8)
Бичиг хэргийн материал	9,015.6	5,806.3	(3,209.3)
Аж ахуйн материал	6,778.6	7,490.1	711.5
Бусад хангамжийн материал	140.0	1,270.0	1,130.0
<b>Дүн</b>	<b>15,934.2</b>	<b>14,566.4</b>	<b>(1,367.8)</b>

*Эх сурвалж: ЭХЗХ-ны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд худалдан авсан 118.4 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 119.7 сая төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдлийн 3.8 сая төгрөг нь Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл, 10.8 сая төгрөг нь Эрчим хүчний зохицуулах хорооны бараа материалын үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

- Архангай аймгийн Зохицуулах зөвлөл: Тайлант онд 1.0 сая төгрөгийн шатахуун, 1.5 сая төгрөгийг сэлбэг хэрэгсэл, 0.4 сая төгрөгийг бичиг хэргийн материал, нийт 2.9 сая төгрөгийн материалыг худалдан авч зарцуулсан боловч бараа материалын тайлан гаргаагүй, жилийн эцсийн санхүүгийн тайланд бараа материалын тодруулгыг батлагдсан маягтын дагуу бэлтгээгүй орхигдуулсан;
- Булган аймгийн Зохицуулах зөвлөл: Бараа материалын тайланд орлого, зарлагын бүртгэл хөтлөөгүй шууд зардалд бүртгэсэн;
- Сүхбаатар аймгийн Зохицуулах зөвлөл: Тайлант онд 1.6 сая төгрөгийн түлш, шатах тослох болон бичгийн хэргийн материал худалдан авсан боловч материалын тайланд орлого, зарлагаар бүртгээгүй шууд зардалд бүртгэсэн.

**3.4.5 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,328.4 сая төгрөг болж, өмнөх оноос 154.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

**Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,083,068.7	4,252,572.4	169,503.7
Барилга, байгууламж, орон сууц	3,432,835.3	3,341,674.0	(91,161.3)
Авто-тээврийн хэрэгсэл	168,722.5	245,493.9	76,771.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	357,149.2	432,797.8	75,648.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	124,361.7	232,063.8	107,702.1
Бусад үндсэн хөрөнгө	-	542.9	542.9
Биет бус хөрөнгө	90,982.9	75,864.3	(15,118.6)
Программ хангамж	55,397.3	40,278.7	(15,118.6)
Бусад биет бус хөрөнгө	35,585.6	35,585.6	0.0
<b>Дүн</b>	<b>4,174,051.6</b>	<b>4,328,436.7</b>	<b>154,385.1</b>

*Эх сурвалж: ЭХЗХ-ны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 162,5 сая төгрөгөөр өсөхөд ТӨБЗГ-ын 2025 оны 802 дугаар тогтоолоор 857.6 сая төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон, 167.7 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 128.7 сая төгрөгийн хөрөнгийг бусад байгууллагаас балансаас баланст шилжүүлэн авсан зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Говьсүмбэр аймгийн Зохицуулах зөвлөл: 6.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоогүй;
- Ховд аймгийн Зохицуулах зөвлөл: Батлагдсан төсөв, тушаал шийдвэргүй 9.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 25,5 сая төгрөг болж, өмнөх оноос 23.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өр төлбөр	-	9,435.3	9,435.3
Дансны өглөг	-	-	-
Байгууллагад төлөх өр төлбөр	-	4,598.5	4,598.5
Хувь хүмүүст төлөх өр төлбөр	-	17.6	17.6
Татварын өр төлбөр	-	8,221.5	8,221.5
НДШ-ийн өр төлбөр	-	2,765.4	2,765.4
Урьдчилж орсон орлого	2,052.4	422.3	(1,630.1)
<b>Дүн</b>	<b>2,052.4</b>	<b>25,460.6</b>	<b>23,408.2</b>

*Эх сурвалж: ЭХЗХ-ны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өр төлбөр дансны үлдэгдэл 23.4 сая төгрөгөөр өмнөх оноос өссөн нь цалин, НДШ, ХХОАТ-ын өглөгийг тайлант онд багтаан шилжүүлээгүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Баян-Өлгий аймгийн Зохицуулах зөвлөл: Тайлант оны өглөг авлагын 28.1 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй;
- Ховд аймгийн Зохицуулах зөвлөл: Батлагдсан төсөв, тушаал шийдвэргүйгээр үндсэн хөрөнгө худалдан авсан.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 10.6 сая төгрөг болж, өмнөх оноос 851.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
----------	----------------	-----------------	------------

**Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан**

			Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	140,123.1	266,829.2	126,706.2
Хуримтлагдсан үр дүн	4,758,405.8	4,994,070.0	235,664.2
Өмнөх үеийн үр дүн	4,758,405.8	4,890,086.7	131,680.9
Тайлант үеийн үр дүн	0.0	103,983.3	103,983.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	75,906.6	329,068.1	253,161.5
<b>Дүн</b>	<b>9,732,841.3</b>	<b>10,584,037.3</b>	<b>851,196.1</b>

*Эх сурвалж: ЭХЗХ-ны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нэгтгэсэн тайлангаар 103.9 сая төгрөгийн үйл ажиллагааны ашигтай ажиллаж, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс 253.2 сая төгрөгөөр, нийт 851.2 сая төгрөгөөр эздийн өмч нэмэгдсэн байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

#### **3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу тус компани нь эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны “Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны зорилтыг батлах тухай” 764 дүгээр тогтоолоор нийт орлогыг 8,397.8 сая төгрөг, нийт зардлыг 9,194.9 сая төгрөгөөр, 797.1 сая төгрөгийн алдагдалтай байхаар, нийт авлага 236.3 сая, нийт өр төлбөрийг 83.0 сая төгрөгөөр тогтоож, нийт ажиллагсдын тоог 98 байхаар баталсан байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны “Хорооны 2025 оны зорилтыг шинэчлэн батлах тухай” 619 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж нийт орлогыг 8,752.4 сая төгрөгөөр тогтоож, цэвэр ашгийг 442.5 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоож, нийт өр төлбөрийг 234.0 сая төгрөг байхаар шинэчлэн тогтоосон байна.

#### **3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 8,885.1 сая төгрөг, бусад орлогоос 55.7 сая төгрөг, нийт 8,940.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, удирдлагын зардалд 641.7 сая төгрөг, НДШ, татвар, хураамжийн зардалд 3,199.7 сая төгрөг, цэвэр ашиг 58.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 8,940.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 188.5 сая төгрөгөөр давсан буюу 102.2 хувьтай байна.

Нийт зардлын гүйцэтгэл 8,837.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 357.1 сая төгрөгөөр буюу 3.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь орон тооны нөхөн хангалт хийгдээгүйгээс шалтгаалан цалин, холбогдох зардлууд дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

#### **3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө батлах тухай” 767 дугаар тогтоолоор нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 175.0 сая төгрөг, гэрээ шууд байгуулах аргаар 422.5 сая төгрөг, харьцуулалтын аргаар 61.6 сая төгрөг, нийт 30 багцын 659.1 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 142.0 сая төгрөг, гэрээ шууд байгуулах аргаар 414.8 сая төгрөг, харьцуулалтын аргаар 141.3 сая төгрөгөөр худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн зохицуулах хороо, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг иж бүрэн байршуулах, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж, дээд шатны байгууллагад хянуулж байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор О.Баярмаа, аудитор Г.Сампилмаа нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг тус тус хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 01/161 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 1.0 хувиар буюу 89.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, албан томилолтоор онгоцоор явахад энгийн ангиллаар зорчих, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх, ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалтыг гүйцэтгэх зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Илрүүлэлт:* Шилэн дансны нэгдсэн системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 202.0 сая төгрөгийн 5 гүйлгээг, зарлагын 43.2 сая төгрөгийн 5 гүйлгээг, нийт 245.2 сая төгрөгийн 10 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн

дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн, үнэн зөв байршуулж, мэдээлэл хоцроох зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэсэн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн. Завсрын аудитаар байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт авч, эрсдэлийг тодорхойлж аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 239.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 10. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	217,374.3	1	217,374.3	100.0
Зөвлөмж	2	22,023.4	2	22,023.4	100.0
Дүн	3	239,397.7	3	239,397.7	100.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлд батлагдсан орон тооны нягтлан бодогч байхгүйгээс санхүүгийн тайлан нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтлөгдөхгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаагаас нэгтгэсэн санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй асуудлыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 154.3 сая төгрөгийн 9 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан.

Аудитаар нийт 218.9 сая төгрөгийн 45 зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 14.1 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 88.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага хүргүүлж, 116.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 26 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 218.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 96.9 сая төгрөгөөс 122.0 сая төгрөгөөс давсан тул “**Хязгаарлалттай**” дүгнэлт өгөв.

### 5.1 Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аймаг, нийслэлийн 22 зөвлөлийн санхүүгийн тайланг нэгтгэснээс 20 зөвлөлийн санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, Говь-Алтай аймаг болон нийслэлийн зохицуулах зөвлөл аудитад хамрагдаагүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 294.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 75.8 сая төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 13.8 сая төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 88.7 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 116.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 26 зөвлөмжийг өгсөн байна.

### 5.2 Эрчим хүчний зохицуулах хороо

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэнд 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

#### 5.3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин 0.3 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

#### 5.3.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Эрчим хүчний зохицуулах хорооны Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Toyota Land Cruiser-J200 маркийн 3508 УББ улсын дугаартай авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг цэнхэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих албан шаардлага хүргүүлэв.

#### 5.3.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 218.9 сая төгрөгийн санхүүгийн зөрчил, нийцлийн аудитын асуудлаар 305.5 сая төгрөгийн зөрчил, нийт 524.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 14.1 сая төгрөгийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 101.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага хүргүүлж, 408.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 28 зөвлөмжийг өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, 6 дугаар зүйлийн 6.6.1-д " төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа зөвлөлүүдийн 2025 оны аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах, дотоод хяналт, удирдлагын тогтолцоог сайжруулж нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандартын дагуу үнэн зөв хөтөлж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

д/д	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Дархан-Уул аймгийн Зохицуулах зөвлөл	3	2,547.5	1	1,059.3	2	1,488.2	3	2,547.5	-	-	-	-
2	Дорноговь аймгийн Зохицуулах зөвлөл	1	4,465.4	-	-	1	4,465.4	1	4,465.4	-	-	-	-
3	Завхан аймгийн Зохицуулах зөвлөл	3	62,741.3	2	61,241.3	1	15,000.0	3	62,741.3	-	-	-	-
4	Ховд аймгийн Зохицуулах зөвлөл	1	6,019.7	-	-	1	6,019.7	1	6,019.7	-	-	-	-
5	Орхон аймгийн Зохицуулах зөвлөл	1	78,500.7	1	78,500.7	-	-	1	78,500.7	-	-	-	-
	ДҮН	9	154,274.6	3	140,801.3	5	26,973.3	9	154,274.6	-	-	-	-

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

**6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл														
		Нийт зөрчил		Үүнээс											Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага						
А	Б	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай аймгийн Зохицуулах зөвлөл	5	48,007.6	1	3,000.0	4	45,007.6	-	-	-	-	-	-	-	-	-
2	Баян-Өлгий аймгийн Зохицуулах зөвлөл	2	33,708.9	-	-	-	-	2	33,708.9	-	-	-	-	-	-	-
3	Баянхонгор аймгийн Зохицуулах зөвлөл	3	300.0	1	300.0	-	-	2	-	-	-	-	-	-	-	-
4	Төв аймгийн Зохицуулах зөвлөл	5	45,730.3	2	3,298.8	1	39,177.6	2	3,253.9	-	-	-	-	-	-	-
5	Булган аймгийн Зохицуулах зөвлөл	3	3,236.8	-	-	-	-	3	3,236.8	-	-	-	-	-	-	-
6	Говьсүмбэр аймгийн Зохицуулах зөвлөл	4	10,580.0	1	830.0	-	-	3	9,750.0	-	-	-	-	-	-	-
7	Дорноговь аймгийн Зохицуулах зөвлөл	6	23,023.8	2	5,833.8	2	480.0	2	16,710.0	-	-	-	-	-	-	-
8	Дорнод аймгийн Зохицуулах зөвлөл	1	4,000.0	-	-	1	4,000.0	-	-	-	-	-	-	-	-	-
9	Завхан аймгийн эрчим хүчний Зохицуулах зөвлөл	4	10,047.0	1	540.0	1	-	2	9,507.0	-	-	-	-	-	-	-
10	Орхон аймгийн Зохицуулах зөвлөл	4	3,944.8	-	-	-	-	4	3,944.8	-	-	-	-	-	-	-
11	Сүхбаатар аймгийн Зохицуулах зөвлөл	1	1,604.5	-	-	-	-	1	1,604.5	-	-	-	-	-	-	-
12	Ховд аймгийн Зохицуулах зөвлөл	5	34,427.7	-	-	-	-	4	34,427.7	-	-	-	-	-	-	-
13	Эрчим хүчний Зохицуулах хороо	2	256.0	1	256.0	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>45</b>	<b>218,867.4</b>	<b>9</b>	<b>14,058.6</b>	<b>10</b>	<b>88,665.2</b>	<b>25</b>	<b>116,143.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Албан шаардлага /Хариуцлага тооцуулах/			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хүний тоо	Тоо
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил															
1	Баянхонгор аймгийн Зохицуулах зөвлөл	1	13,275.6	-	-	1	13,275.6	-	-	-	-	-	-	-	-
2	Завхан аймгийн эрчим хүчний Зохицуулах зөвлөл	1	46,974.2	-	-	-	-	1	46,974.2	-	-	-	-	-	-
3	Төв аймгийн эрчим хүчний Зохицуулах зөвлөл	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
4	Эрчим хүчний Зохицуулах хороо	1	245,203.2	-	-	-	-	1	245,203.2	-	-	-	-	-	-
	Дүн	4	305,453.0	-	-	1	13,275.6	3	292,177.4	-	-	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 121/СО111411

Улаанбаатар хот

САГ - 2026/102/НА - СТА - ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин 256,000.00 /хоёр зуун тавин зургаан мянган/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх", 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Бэлэг дурсгалын зүйл худалдан авсан 256,000.00 /хоёр зуун тавин зургаан мянган/ төгрөгийг ерөнхий нягтлан бодогч М.Мандахаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга /Э.Түвшинчулуун/-д хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
С.САМПИЛМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 554/СО111411

Улаанбаатар хот

САГ-2026/102/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 1 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "бодитой байх", 4.2.2-т "хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солиогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга /Э.Түвшинчулуун/, ерөнхий нягтлан бодогч /М.Мандах/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

*Signature*

Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
Г.САМПИЛМАА

